



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2019 оны 05 сарын 23 өдөр

Дугаар A/29

Улаанбаатар хот

Төвийн ажиллагсадыг хепатитын В вирусын эсрэг
Дархлаа тогтоц тодорхойлох шинжилгээнд хамруулах
ажлын зардал гаргах тухай

Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/288 тоот тушаалын 3 дугаар хавсралтын 1.3, 3.4 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн ажиллагсадыг Хепатитын В вирусын эсрэг дархлаа тогтоц тодорхойлох шинжилгээнд хамруулах ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлаас зарцуулахыг Ахлах нягтлан бодогч /Ө.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Үйл ажиллагааг удирдамжийн дагуу зохион байгуулахыг Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч /М.Цэрэндэжид/, Чанарын менежер /Э.Тунгалагтуяа/ нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /Д.Амар/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

D:\bichig hereg\ALBAN BICHIG\Tushaal\ 2019\A.docx

080021

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2019 оны 05 дүгээр сарын 23-ний өдрийн
№29 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Төвийн ажиллагсадыг хепатитын В вирус, эсрэг
Дархлаа тогтоц тодорхойлох шинжилгээнд
хамруулах ажлын удирдамж

Нэг. Үндэслэл

Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажил үүргээ гүйцэтгэх үедээ бохирлогдсон зүү тариуранд хатгагдснаас цусан халдвар авах эрсдэлтэй байдаг бөгөөд ДЭМБ-ын мэдээгээр анхаарал болгоомжгүйгээс энэ төрлийн гэмтэлд өртөж жил бүр эмнэлгийн 66000 ажиллагсад хепатитын В вирус (HBV), 200-5000 ажиллагсад ХДХВ-ийн халдварыг авдаг байна.

Цусаар дамжих халдвар дундаас хамгийн түгээмэл тохиолддог нь хепатитын В вирус (ХВВ), С вирус (ХСВ), ХДХВ-ийн халдвар юм. Монгол Улс ХВВ, ХСВ-ийн халдварын тархалт өндөртэй орны нэг төдийгүй элэгний хатуурал, хавдрын өвчлөлөөрөө дэлхийд тэргүүлсээр байна.

М.Мөнхнасан П.Нямдаваа нарын 2016 оны Эрүүл мэндийн ажилтны цусаар дамжих халдварын тархалтын судалгаагаар Хот, хөдөөгийн эрүүл мэндийн ажилтнуудын 28.8 хувь нь ХВВ, ХСВ-н дан ба хавсарсан халдвартай, мөн 89.7% нь HBV-DNA, 46.2%-д HCV-RNA эерэг тодорхойлогдож В хепатитийн эсрэг вакцинжуулалтын хамралт, дархлааны түвшин эрүүл мэндийн ажилтнуудад хангалтгүй байна гэсэн дүгнэлт гарсан байна

В гепатитын халдвараас сэргийлэх хамгийн сайн арга бол вакцинд хамрагдах юм. ЦССҮТ нь нийт ажиллагсадаа 2011 оноос вакцинд жил бүр хамруулан ирсэн. 2019 оны байдлаар нийт ажиллагсад /жирэмсний амралттай 6 ажилтан хамрагдсан/-ын 87% (65) В хепатитын вакцинд хамрагдсан, 12% (9) хамрагдаагүй байна. Ажиллагсадын хепатитын В вирус эсрэг дархлаа тогтоцыг тодорхойлох нь халдварын эрсдэлээс сэргийлэх чухал үйл ажиллагаа юм.

Хоёр. Зорилго

Нийт ажиллагсадын хепатитын В вирус эсрэг дархлаа тогтоцыг тодорхойлох

Гурав. Зорилт

Төвийн нийт ажиллагсадыг хепатитын В вирусын эсрэг дархлаа тогтоц тодорхойлох шинжилгээнд хамруулж, давтан дархлаажуулалтанд хамрагдах ажиллагсадыг тодорхойлох

Дарөв. Хугацаа

2019.06.10-2019.06.21


Тав. Хариуцах эзэн

Чанарын алба, Нэгдсэн лабораторийн тасаг, Халдварын сэргийлэлт хяналтын баг

Зургаа. Хүрэх үр дүн

Дархлаа тогтоц буурсан, дахин дархлаажуулалтанд хамрагдах ажиллагсадыг тодорхойлсноор В хепатитын халдвараас сэргийлж, ажиллагсадын ажлын чадамжийг сайжруулна.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
 2019 оны дүгээр сарын.....-ний өдрийн
тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Төвийн ажиллагсадыг хепатитын В вирусын эсрэг
 Дархлаа тогтоц тодорхойлох шинжилгээнд
 хамруулахад шаардагдах төсөв

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын буюу ерөнхий нэршил	Савлалтын хэмжээ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	ХВВ-ийн эсрэг дархлаа тогтоц	HSCL HBsAb	100 test	хайр	1	644,000	644,000
2	Калибратор	HBsAb cal	1ml*6	хайр	1	331,000	331,000
3	Хяналтын материал	Viratrol	3ml*3	хайр	1	271,000	271,000
4	Субстрат	substrate	600test	хайр	1	450,000	450,000
5	Угаагч уусмал	Washing sol	2 L	хайр	1	186,000	186,000
6	Угаагч уусмал	Line washing	10 L	хайр	1	103,000	103,000
7	Угаагч уусмал	Probe washing	250 ml*2	хайр	1	137,000	137,000
Нийт үнэ:							2,122,000